ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН ХҮҮХДИЙН ДӨРӨВДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2026 оны 01 сарын 11 өдөр Дугаар А/04 Бор-Өндөр сум

Мэргэжлийн багш нарын бүлэг байгуулах
тухай

Монгол Улсын Боловсролын Ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.3 дэх заалт, Багшийн хөгжлийн дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дах хэсэг, Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/25 дугаар тушаалын нэг дүгээр хавсралт тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Багш нарын мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журмыг нэгдүгээр хавсралт, цэцэрлэгийн мэргэжлийн багш нарын бүлгийн ахлагч, гишүүдийг хоёрдугаар хавсралтаар баталсугай. .

2.Багш нарын багшлахуй, суралцахуйд тулгамдаж байгаа асуудлыг илрүүлж, шийдлийг гарган ажиллах, багшлах суралцахуй үйл гарч байгаа ахиц өөрчлөлт, үр дүнг бусадтай хуваалцан хамтарч ажиллахыг мэргэжлийн багш нарын ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Мэргэжлийн бүлгийн ахлагч болон гишүүдэд арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг арга зүйч (Ц. Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЭРХЛЭГЧИЙН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ө.АЛЬМАА

1825010070 4216583

Galaxy A15

Бор-Өндөр сумын 4-р цэцэрлэгийн
Эрхлэгчийн 2026 оны 01 сарын 11-ний
өдрийн 2/04 тоот тушаалын хавсралт

БОР-ӨНДӨР СУМЫН 1,2,3,4 - ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН МЭРГЭЖЛИЙН БАГШ
НАРЫН БҮЛГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

2026 оны 01 дугаар сарын 11

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Нийгмийн шинэ нөхцөл байдал хурдацтай хөгжил дэвшлийн эрин үед нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангасан цогц чадамж бүхий хүний хөгжлийн асуудал тэр дундаа багшийн хамтын оролцоо, манлайлал чухлаар тавигдаж байна.

Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих, ажлын байрандаа бие даан өөрийгөө хөгжүүлэх, бусадтай хамтран ажиллах, харилцан суралцах замаар тасралтгүй хөгжлөө хангахад чиглүүлж байгаа бөгөөд Мэргэжлийн багш нарын бүлэг нь багш нарын хамтран ажиллах бүлэг болох ба МБНБ хэрхэн ажиллах талаар энэхүү журамд тусгасан болно.

1.1. ЗОРИЛГО, ХҮРЭХ ҮР ДҮН

Мэргэжлийн багш нарын бүлэг нь багш нар багшлахуй болон суралцахуйд тулгамдсан асуудалд анхаарлаа төвлөрүүлэх, хамтран ажиллах, ажлын байрандаа багш мэргэжлийн тусгай болон ерөнхий ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд оршино.

Хүрэх үр дүн:

- Багш нар харилцан суралцах, хамтран хөгжих шинэ соёл арга барилд суралцана.
- Багшлахуйд тодорхой ахиц гарна
- Хүүхдийн хөгжилд ахиц гарна

1.2. ЗАРЧИМ :

- ✓ Суралцахуй болон багшлахуйн хөгжлийг дэмжсэн байна
- ✓ Асуудал төвтэй бүтээлч үйл ажиллагаанд суурилсан байна
- ✓ Хамтран ажиллах, харилцан суралцах соёлыг бүтээсэн байна
- ✓ Бүтэц зохион байгуулалтын хувьд уян хатан байна
- ✓ Итгэлцэл, хамтын хариуцлага, тэгш оролцоо, манлайлалд тулгуурласан байна

ХОЁР. МЭРГЭЖЛИЙН БАГШ НАРЫН БҮЛГИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Суралцахуйд суурилсан мэргэжлийн хөгжлийн бүлэг:

Багшийн мэргэжлийн ур чадварыг дэмжих бүлгийг хүүхдийн хөгжил, суралцахуйг дэмжих зорилгоор МБНБ-ийг түшиглэн байгуулна. Энэхүү бүлэг нь МБНБ болон сургалт, үйл ажиллагаанаас үл хамаарч хүүхдийн хөгжлийн тодорхой асуудалд төвлөрөн зохион байгуулалт, үйл ажиллагааны олон хэлбэртэй байж болно. Тухайлбал:

Galaxy A15

- ❖ Анги бүлэг

- Хүсэл сонирхолоороо нэгдсэн бүлэг байж болно

2.2 Багш бүр сургалт үйл ажиллагааны явц, өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний үр дүнд дүн шинжилгээ хийж хүүхдийн суралцахуйд үүсэж буй бэрхшээл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тусгамдсан асуудлыг тодорхойлсон байна

2.3. Багш нар мэргэжлийн багш нарын бүлгийг өөрсдөө зохион байгуулах ямар бүлэгт нэгдэхээ сонгож болно.

2.4. Мэргэжлийн хөгжлийн бүлгийн удирдлага

2.4.1. Арга зүйч чиглүүлэн, менежментээр дэмжин ажиллах ба МБнБ-ийг туршлагатай, манлайлагч багшаар ахлагчийг сонгон удирдуулна

2.5. МБНБ-ийн үйл ажиллагааны хэрэгжилт

2.5.1. МБНБ дараах асуудалд төвлөрнө Үүнд:

- Хүүхдийн хоцрогдлыг шалтгааныг илрүүлэх, оношлох, нөхөх, арилгах шийдлүүдийг төлөвлөн хэрэгжүүлэх
- Бүлгийн гишүүн бүр сайн туршлага, инновацийг судлах, турших, хэрэгжүүлэх үр дүнг хэлэлцэх
- Хамтарсан судалгаа хийх, илтгэл хэлэлцүүлэх
- Хүүхдийн хөгжил, төлөвшил хамгааллын талаар сайн туршлага судлах, турших түгээх

2.6. МБНБ-ийн үйл ажиллагааны хэрэгжилт :

МБНБ нь тодорхой асуудлыг сонгон хэрэгжүүлэхдээ дараах алхмын дагуу ажиллана

- Бүлгийн гишүүд харилцан ойлголцоно
- Хамтдаа сонгосон асуудлыг талаар ярилцаж туршлага мэдээлэл солилцоно.
- Сонгосон асуудлаа шийдвэрлэх арга замаа хэлэлцэнэ
- Үйл ажиллагаа, арга зүйг төлөвлөнө.
- Бүтээлч эрэлхийлэл хийж, шинэ материал, шинэ технологи судлах, шинэ санаа боловсруулна
- Арга зүйн санаа үйл ажиллагааг гишүүн бүр туршиж хэрэгжүүлж, үр дүнгээ хэлэлцэж алдаагаа шинжлэн, сайжруулна
- Хүрсэн үр дүнгээ өөр хоорондоо болон бусад бүлгүүдтэй хуваалцана, түгээнэ.

ГУРАВ. МБНБ-т ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮҮРЭГ

3.1. Бүлгийн гишүүдийн үүрэг:

- МБНБ-ийн зорилго, хүрэх үр дүн, бүлгийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад бүтээлч санаачлагатай оролцоно.
- Бүлгийн судалж буй асуудлын шийдэл, арга зүйн санааг турших, хэрэгжүүлэх, үр дүнг хуваалцана.
- МБНБ-ийн хамтран ажиллах соёлыг төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулна

3.2. Бүлгийн ахлагчийн үүрэг

-МБнБ-ийн зорилгод чиглэсэн үйл ажиллагааг гишүүдийн идэвх оролцоо санаачлагын үндсэн дээр төлөвлөн хэрэгжүүлэхэд чиглүүлэн ажиллана.

Galaxy A15

-Бүлгийн үйл ажиллагааны явцын болон үр дүнгийн хэлэлцүүлгийг зохион байгуулах, гишүүдийн ойлголтыг нэгтгэхэд санаачлага, манлайлалтай ажиллана

-Бүлгийн үйл ажиллагааны төлөвлөлтийг хэрэгжүүлэх явцад асуудал, бэрхшээл гарвал шийдвэрлэх алхам, санал санаачлага гарган гишүүдтэйгээ ярилцан олонхийн саналаар шийдвэрлэнэ.

-Бүлгийн гишүүдийн хамтын үнэ цэн, ялгаатай байдлыг хүндэтгэн үзэж, ажил үүргийн хуваарилалт хийх, тэгш оролцоог хангаж ажиллана

-Бүлгийн үйл ажиллагааг нээлттэй бусад бүлгүүдтэй хамтран ажиллахад чиглүүлнэ

3.3. Арга зүйч чиглүүлэгчийн үүрэг:

- ✓ МБНБ-ийн үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх, ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлнэ
- ✓ Бүлэгт ажиллаж буй багш нарын идэвх оролцоо, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахицыг багшийн өөрийн үнэлгээг харгалзан тооцон ажиллана
- ✓ Хүний нөөцийг зөв хуваарилах, цагийн хуваарьт зохицуулалт хийх зэргээр бүлгийн үйл ажиллагаанд менежментийн зохицуулалт хийнэ
- ✓ Бүлгийн ерөнхий мэдээлэл, үйл ажиллагааны явц, үр дүн тулгамдсан асуудал, бэрхшээл, шийдлээр улирал тутам хэлэлцүүлэг зохион байгуулна
- ✓ Бүлгийн бусдад түгээн дэлгэрүүлэх боломжтой сайн туршлага, шинэ санаагаар контент бүтээн хичээлийн жилийн төгсгөлд БГ-Т хүргүүлнэ

МЭРГЭЖЛИЙН БАГШ НАРЫН БҮЛЭГ

Galaxy A15